



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/08/НА-СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Энхдалай
Утас: 261885 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn
Ахлах аудитор: Ц.Энхжаргал
Утас: 261740 Цахим хаяг: enkhjargalts@audit.gov.mn

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга.....	12
3.5.1 Мөнгөн хөрөнгө.....	12
3.5.2 Авлага	13
3.5.3 Урьдчилгаа	13
3.5.4 Бараа материал	14
3.5.5 Нөөцийн бараа	14
3.5.6 Бусад эргэлтийн хөрөнгө	15
3.5.5 Үндсэн хөрөнгө	15
3.5.6 Өр төлбөр	16
3.5.7 Засгийн газрын хувь оролцоо	16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	18
3.8 Аудитын гол асуудал	19
3.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..	19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
4. Аудитын илрүүлэлт	21
4.1 Харьяа байгууллагууд.....	21
4.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч.....	21
4.2.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулсан алдаа	21
4.2.2 Төлбөрийн акт	21
4.2.3 Албан шаардлага.....	22
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	23
5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл	23
5.2 Нийцлийн аудитын асуудлаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл.....	26
6. Акт, Албан шаардлага.....	29

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОБГ	Онцгой байдлын газар
ОБХ	Онцгой байдлын хэлтэс
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА, ХОШУУЧ ГЕНЕРАЛ
Г.АРИУНБУЯН ТАНАА

2022.03.25 № 01/718
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Онцгой байдлын ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 9,368.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч, тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7, 15 дугаар зүйлийн 15.4, 16 дугаар зүйлийн 16.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5 дахь заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САРАНСҮХ

2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	135,614,430.8	145,952,220.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,109,957.7	340,191.9
33	АВЛАГА	17,783,700.8	15,162,045.7
34	УРЬДЧИЛГАА	1,301,369.2	8,892,488.1
35	БАРАА МАТЕРИАЛ	43,922,266.2	39,688,406.6
36	НӨӨЦИЙН БАРАА	70,497,136.9	69,193,688.2
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	0.0	12,675,400.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	204,689,348.8	262,852,357.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	204,689,348.8	262,852,357.6
39200	Биет хөрөнгө	175,162,797.0	233,078,480.3
39300	Биет бус хөрөнгө	29,526,551.8	29,773,877.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	340,303,779.6	408,804,578.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,975,432.5	2,486,598.8
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,975,432.5	2,486,598.8
412	Богино хугацаат зээлийн өглөг	183,814.5	158,502.3
41300	Өглөг	2,176,001.1	2,327,596.5
41400	Урьдчилж орсон орлого	615,617.0	500.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	337,328,347.1	406,317,979.2
51	Засгийн газрын хувь оролцоо	337,328,347.1	406,317,979.2
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	90,485,170.0	94,915,269.6
51200	Хуримтлагдсан үр дүн	196,842,301.1	261,317,363.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	50,000,876.0	50,085,346.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	340,303,779.6	408,804,578.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	201,380,168.9	255,702,692.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	63,292,192.7	84,045,204.1
120	Нийтлэг татварын бус орлого	63,292,192.7	84,045,204.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	138,087,976.2	171,657,488.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	163,763,224.0	167,232,265.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	163,763,224.0	167,232,265.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	152,821,488.4	156,880,046.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	63,022,177.1	68,110,859.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,886,797.2	2,068,626.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,349,417.1	4,775,185.5
2104	Хангамж, бараа материалын зардал	5,050,734.5	6,141,945.5
2105	Нормативт зардал	5,802,817.3	9,945,396.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,620,389.3	5,095,211.0
2107	Томилолт, зочны зардал	1,579,798.8	2,830,477.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,045,374.0	10,013,570.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,463,983.0	47,898,772.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,941,735.5	10,352,219.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	37,616,944.9	88,470,426.3
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	145,400.0	4,151.5
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,027,993.7	20,106,615.1
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	35,734,351.2	68,367,962.7

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	307,450,401.8	0.0	307,450,401.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-3,717,327.9	0.0	-3,717,327.9
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	303,733,073.9	0.0	303,733,073.9
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-1,905,078.0	0.0	-1,905,078.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-234,000.0	0.0	-234,000.0
9	Тайлант үеийн үр дүн	35,734,351.2	0.0	35,734,351.2
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	337,328,347.1	0.0	337,328,347.1
11	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	337,328,347.1	0.0	337,328,347.1
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	537,199.3	0.0	537,199.3
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	337,865,546.4	0.0	337,865,546.4
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	84,470.1	0.0	84,470.1
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	68,367,962.7	0.0	68,367,962.7
20	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	406,317,979.2	0.0	406,317,979.2

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	170,580,536.4	187,855,087.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	32,369,759.5	14,010,914.7
120	Нийтлэг татварын бус орлого	32,369,759.5	14,010,914.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	138,210,776.9	173,844,172.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	155,517,999.4	157,102,574.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	155,517,999.4	157,102,574.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	142,716,885.1	146,206,942.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	62,651,495.2	67,493,612.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,929,567.9	2,090,443.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,373,850.1	4,773,373.3
2104	Хангамж, бараа материалын зардал	3,666,460.5	4,118,992.5
2105	Нормативт зардал	7,405,222.1	10,048,808.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,091,942.4	4,255,824.4
2107	Томилолт, зочны зардал	1,463,048.6	2,779,764.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,138,252.1	15,024,844.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,997,046.2	35,621,280.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,801,114.3	10,895,631.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	15,062,537.0	30,752,513.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	13,316,284.2	32,522,279.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,316,284.2	32,522,279.2
2200	Дотоод эх үүсвэрээр	13,316,284.2	32,522,279.2
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-13,316,284.2	-32,522,279.2
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,746,252.8	-1,769,765.8
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	363,704.9	2,109,957.7
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,109,957.7	340,191.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	146,942,807,900.00	145,277,565,361.07	1,665,242,538.93	98.9
УРСГАЛ ЗАРДАЛ	119,587,665,700.00	117,936,208,040.77	1,651,457,659.23	98.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	110,992,096,600.00	109,344,035,264.02	1,648,061,335.98	98.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	67,942,921,200.00	66,981,368,455.86	961,552,744.14	98.6
Үндсэн цалин	39,736,680,200.00	39,472,535,944.39	264,144,255.61	99.3
Нэмэгдэл	26,632,646,100.00	25,929,196,743.41	703,449,356.59	97.4
Унаа хоолны хөнгөлөлт	1,573,594,900.00	1,579,635,768.06	-6,040,868.06	100.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,166,433,300.00	2,031,044,899.57	135,388,400.43	93.8
Тэтгэврийн даатгал	852,796,400.00	716,744,369.36	136,052,030.64	84.0
Тэтгэмжийн даатгал	117,303,500.00	104,710,100.00	12,593,400.00	89.3
ҮОМШӨ-ний даатгал	90,161,100.00	82,882,961.00	7,278,139.00	91.9
Ажилгүйдлийн даатгал	18,824,000.00	16,739,750.00	2,084,250.00	88.9
Эрүүл мэндийн даатгал	1,087,348,300.00	1,109,967,719.21	-22,619,419.21	102.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,041,583,200.00	4,675,992,921.09	365,590,278.91	92.7
Гэрэл, цахилгаан	1,218,456,200.00	974,033,306.28	244,422,893.72	79.9
Түлш, халаалт	3,131,183,900.00	3,070,395,793.27	60,788,106.73	98.1
Цэвэр, бохир ус	335,309,500.00	276,028,708.27	59,280,791.73	82.3
Байрны түрээс	356,633,600.00	355,535,113.27	1,098,486.73	99.7
Хангамж, бараа материалын зардал	3,403,792,600.00	3,373,506,000.40	30,286,599.60	99.1
Бичиг хэрэг	174,074,500.00	173,738,969.63	335,530.37	99.8
Тээвэр, шатахуун	2,707,795,100.00	2,710,920,538.00	-3,125,438.00	100.1
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	171,658,400.00	153,890,464.77	17,767,935.23	89.6
Ном, хэвлэл	9,714,800.00	9,504,950.00	209,850.00	97.8
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	30,461,700.00	24,404,487.00	6,057,213.00	80.1
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	310,088,100.00	301,046,591.00	9,041,509.00	97.1
Нормативт зардал	9,262,434,600.00	9,238,030,307.00	24,404,293.00	99.7
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	120,652,800.00	117,233,506.00	3,419,294.00	97.2
Хоол, хүнс	2,857,229,000.00	2,836,934,055.00	20,294,945.00	99.3
Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,284,552,800.00	6,283,862,746.00	690,054.00	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	6,534,373,800.00	6,506,998,041.25	27,375,758.75	99.6
Багаж, техник, хэрэгсэл	1,577,378,600.00	1,567,992,982.00	9,385,618.00	99.4
Тавилга	5,280,000.00	5,280,000.00	0.00	100.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	92,332,700.00	89,582,700.00	2,750,000.00	97.0
Урсгал засвар	4,859,382,500.00	4,844,142,359.25	15,240,140.75	99.7
Томилолт, зочны зардал	75,889,600.00	63,856,680.00	12,032,920.00	84.1
Дотоод албан томилолт	75,889,600.00	63,856,680.00	12,032,920.00	84.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,674,228,500.00	15,587,595,319.29	86,633,180.71	99.4
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,642,907,900.00	11,623,739,061.94	19,168,838.06	99.8
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	25,728,600.00	24,152,300.00	1,576,300.00	93.9
Даатгалын үйлчилгээ	3,665,719,600.00	3,649,202,624.70	16,516,975.30	99.5
Тээврийн хэрэгслийн татвар	84,947,800.00	63,447,369.00	21,500,431.00	74.7
Тээврийн хэрэгслийн оношилгоо	28,029,400.00	20,916,296.00	7,113,104.00	74.6
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	55,133,500.00	51,455,710.00	3,677,790.00	93.3
Газрын төлбөр	171,595,000.00	154,681,957.65	16,913,042.35	90.1
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	166,700.00	0.00	166,700.00	0.0
Бараа үйлчилгээний бусад зардал	890,439,800.00	885,642,639.56	4,797,160.44	99.5
Бараа үйлчилгээний бусад зардал	259,859,000.00	259,798,537.56	60,462.44	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	630,580,800.00	625,844,102.00	4,736,698.00	99.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,595,569,100.00	8,592,172,776.75	3,396,323.25	100.0
Засгийн газрын урсгал шилжүүлэг	106,010,000.00	105,735,813.75	274,186.25	99.7

Онцгой байдлын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Засгийн газрын гадаад шилжүүлэг	106,010,000.00	105,735,813.75	274,186.25	99.7
Бусад урсгал шилжүүлэг	8,489,559,100.00	8,486,436,963.00	3,122,137.00	100.0
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	139,300,000.00	139,240,950.00	59,050.00	100.0
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,500,000.00	4,500,000.00	0.00	100.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,839,779,100.00	7,839,779,100.00	0.00	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	505,980,000.00	502,916,913.00	3,063,087.00	99.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	27,355,142,200.00	27,341,357,320.30	13,784,879.70	99.9
Барилга байгууламж	12,675,400,000.00	12,675,400,000.00	0.00	100.0
Тоног төхөөрөмж	100,000,000.00	100,000,000.00	0.00	100.0
Бусад хөрөнгө	6,500,000,000.00	6,496,766,716.00	3,233,284.00	100.0
Стратегийн нөөц хөрөнгө	8,079,742,200.00	8,069,190,604.30	10,551,595.70	99.9
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	146,942,807,900.00	145,357,392,636.77	1,585,415,263.23	98.9
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	141,680,668,900.00	140,010,968,701.19	1,669,700,198.81	98.8
Улсын төсвөөс санхүүжих	141,680,668,900.00	140,010,968,701.19	1,669,700,198.81	98.8
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,262,139,000.00	5,346,423,935.58	-84,284,935.58	101.6
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,262,139,000.00	5,346,423,935.58	-84,284,935.58	101.6

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		37,461,838,543.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ		36,899,843,540.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		36,041,845,141.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		89,054,266.00
210102	Нэмэгдэл		67,101,295.00
210105	Гэрээт ажлын хөлс		21,952,971.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		94,339,344.70
210301	Гэрэл, цахилгаан		11,311,744.70
210302	Түлш, халаалт		10,087,600.00
210304	Байрны түрээс		72,940,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		809,482,513.00
210401	Бичиг хэрэг		51,074,580.00
210402	Тээвэр, шатахуун		674,193,990.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		20,117,116.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		64,096,827.00
2105	Нормативт зардал		1,272,824,686.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		311,317,490.00
210502	Хоол, хүнс		830,087,196.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		131,420,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		621,790,769.90
210601	Багаж, техник, хэрэгсэл		132,302,400.00
210602	Тавилга		350,000.00
210604	Урсгал засвар		489,138,369.90
2107	Томилолт, зочны зардал		2,715,907,404.00
210702	Дотоод албан томилолт		2,715,650,404.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		257,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		4,370,280,947.29
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		4,361,171,147.29
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		9,109,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		26,068,165,210.69
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		26,050,559,016.69
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		17,606,194.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		857,998,398.50
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		6,067,824.60
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		6,067,824.60
2132	Бусад урсгал шилжүүлэг		203,417,128.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		24,010,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		179,407,128.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		648,513,445.90
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		533,471,450.91
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		115,041,994.99
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		561,995,003.00
2200	Дотоод эх үүсвэрээр		561,995,003.00
220001	Барилга байгууламж		48,000,000.00
222001	Тоног төхөөрөмж		18,000,000.00
223001	Бусад хөрөнгө		70,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		425,995,003.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		37,461,838,543.08
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		37,461,838,543.08
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		3,217,488,129.98
131103	ЗГНХ, ЗДНХ, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		22,090,465,878.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		5,087,362,725.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		7,066,521,810.10

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдрөөс 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн хооронд Үндэсний аудитын газрын Аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор Ц.Энхжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Энхдалай, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Сарансүх нар хэрэгжүүлсэн.

Онцгой байдлын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 9/444 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Онцгой байдлын ерөнхий газар нь гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах үндсэн чиг үүрэг бүхий байгууллага юм.

Тайлант онд онцгой байдлын албаны техник багаж, тоног төхөөрөмж, хувцас хэрэгслийн чанар, ашиглалтыг сайжруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологийг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг цахимжуулах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль тогтоомж, бодлого, чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль;
- Засгийн газрын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоол;
- Сангийн сайдын 2021 оны “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг шинэчлэн батлах тухай” 190 дүгээр тушаал

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны А/293 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын газраас нийслэлийн 5 дүүрэгт иж бүрэн шалгалт хийх, Онцгой байдлын ерөнхий газрын харьяа 7 байгууллагад биелэлтийн шалгалтыг хийх төлөвлөгөө баталсан байна. Коронавируст халдварт Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан иж бүрэн шалгалтын ажлыг хойшлуулан, биелэлтийн шалгалтад

хамрагдах байгууллагуудын зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг урьдчилан авч, цахим шалгалтыг зохион байгуулсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын зорилго оршино.

Онцгой байдлын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил, гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн болно.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан, суурь үзүүлэлтийг нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлын түвшинг санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 163,763.2 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 1,637.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

Онцгой байдлын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10,337.8 сая төгрөгөөр буюу 7.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материал, нөөцийн бараа, бусад эргэлтийн хөрөнгө, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данснуудад материаллаг өөрчлөлт гарсан байна.

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 340.2 сая төгрөг болж, өмнөх оноос 1,769.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	137.6	0.0	-137.6
Банканд байгаа бэлэн мөнгө	2,109,820.1	340,191.9	-1,769,628.2
Төрийн сангийн харилцах	246,289.6	257,129.7	10,840.2
Арилжааны банк дахь харилцах	1,863,530.5	83,062.2	-1,780,468.4
Дүн	2,109,957.7	340,191.9	-1,769,765.8

Эх сурвалж: ОБЕГ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 257.1 сая төгрөг Төрийн сангийн харилцах дансанд, 83.1 сая төгрөг арилжааны банкны дансанд байршиж байна.

Аудитын илрүүлэлт:

- Анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж, данс бүртгэлд тусгасан, төлбөрийн цахим баримтгүйгээр бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан; /Сэлэнгэ аймгийн ОБГ 468.2 сая, Нийслэлийн ОБГ 85.2 сая, Чингэлтэй дүүргийн ОБХ 33.5 сая, Баянгол дүүргийн ОБХ 16.5 сая, Сүхбаатар дүүргийн ОБХ 10.1 сая, Хан-Уул дүүргийн ОБХ 9.6 сая, Баянзүрх дүүргийн ОБХ 9.5 сая, Багахангай дүүргийн ОБХ 8.1 сая, Налайх дүүргийн ОБХ 3.4 сая төгрөг/
- Холбогдох эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр арилжааны банканд данс нээж, 1,215.4 сая төгрөгийн гүйлгээ хийсэн; /ОБЕГ-ын дэргэдэх 121 дүгээр анги/
- Өндөр насны тэтгэвэрт гараад ажиллаж байгаа 9 албан хаагчид удаан жилийн нэмэгдэл 5,759.6 сая төгрөгийг илүү олгосон; /Үндэсний аврах бригад/
- Тэтгэвэрт гарсан ажилтнуудыг төрийн албан хаагчаар томилж, 5.0 сая төгрөгийн цалингийн нэмэгдэл, урамшууллыг олгосон; /Дундговь аймгийн ОБГ/
- Сахилгын шийтгэлтэй байсан 7 албан хаагчид 3.7 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон; /Дархан-Уул аймгийн ОБГ/
- Албан хаагчдын ээлжийн амралтын дундаж цалинг тооцохдоо хоолны мөнгийг оруулан тооцож 2.1 сая төгрөгийг илүү олгосон; /Дорнод аймгийн ОБГ/
- Зардлын эдийн засгийн ангилал зөрчиж, бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан; /Орхон аймгийн ОБГ 51.0 сая, Үндэсний аврах бригад 11.2 сая/
- Барилгын ажлын гүйцэтгэгчээс 670.5 сая төгрөгийн чанарын баталгааны барьцааг суутгаагүйгээр санхүүжилтийг олгосон; /ОБЕГ/ зэрэг.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 15,162.0 сая төгрөг болж, өмнөх оноос 2,621.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Авлага дансны үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбогдсон авлага	16,151.1	15,831.8	-319.2
Төлбөртэй үйлчилгээний авлага	1,826.2	0.0	-1,826.2
Татаас, санхүүжилтийн авлага	1,730,323.3	530,634.7	-1,199,688.7
Байгууллагаас авах авлага	15,991,856.2	14,575,869.1	-1,415,987.1
Хувь хүмүүсээс авах авлага	43,544.0	39,710.1	-3,833.9
Дүн	17,783,700.8	15,162,045.7	-2,621,655.1

Эх сурвалж: ОБЕГ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэл буурсан нь татаас санхүүжилтийн авлага 1,946.6 сая, улсын нөөцийн бараа шинэчлэл сэлгэлттэй холбоотой авлага 1,060.4 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Авлагын үлдэгдэлд улсын нөөцийн бараа сэлгэлттэй холбоотой таваас дээш жилийн насжилттай 14,501.6 сая төгрөгийн авлага байна.

Аудитын илрүүлэлт:

- Авлагыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй; /ОБЕГ-аппарат 245.0 сая, Орхон аймгийн ОБГ 32.0 сая, Үндэсний аврах бригад 1.2 сая төгрөг/
- Тайланд онд авлага үүсгэсэн; /Давтан сургалт сэргээн заслын төв 5.6 сая, Сүхбаатар дүүргийн ОБХ 1.6 сая/ зэрэг.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 8,892.5 сая төгрөг болж, өмнөх оноос 7,591.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	1,301,369.2	8,892,488.1	7,591,118.8
Дүн	1,301,369.2	8,892,488.1	7,591,118.8

Урьдчилгаа дансны үлдэгдэл өссөн нь хил дээр байгаа бараа материалын тээвэрлэлт саатсантай холбоотой 7,408.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, бараа материал нийлүүлэгдээгүй, нисдэг тэрэг, алба хаагчдын гэнэтийн ослын даатгал болон нөөцийн барилга байгууламж, тоног төхөөрөмж, бараа материалын даатгалын хураамж 1,299.3 сая төгрөгийг гэрээний хугацаанд ногдохыг урьдчилж төлсөн зардлаар бүртгэсэнтэй холбоотой байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 39,688.4 сая төгрөг болж, өмнөх оноос 4,233.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материал дансны үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	25,935,359.6	16,665,153.3	-9,270,206.3
Эм боох	418,474.4	786,807.3	368,333.0
Дуусаагүй үйлдвэрлэл	24,892.5	24,892.5	0.0
Бэлэн бүтээгдэхүүн	2,214,659.9	4,150,444.5	1,935,784.6
Бичиг хэргийн материал	176,078.9	282,677.7	106,598.8
Аж ахуйн материал	2,829,606.0	3,908,379.1	1,078,773.1
Сэлбэг хэрэгсэл	538,274.5	874,808.2	336,533.7
Түлш, шатах тослох материал	374,287.0	379,867.6	5,580.6
Барилгын засварын материал	88,515.0	206,714.2	118,199.2
Хүнсний материал	108,690.0	835,833.3	727,143.3
Бусад хангамжийн материал	11,051,354.9	11,328,756.5	277,401.6
Биологийн хөрөнгө	110,184.5	184,445.4	74,260.8
Мал амьтад	51,889.0	59,627.0	7,738.0
Дүн	43,922,266.2	39,688,406.6	-4,233,859.5

Эх сурвалж: ОБЕГ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал дансны үлдэгдэл буурсан нь Коронавируст халдварт цар тахалтай холбоотойгоор иргэд байгууллагуудаас ирсэн хандивыг холбогдох байгууллагуудад шилжүүлсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- Бараа материалын тайлангийн анхан шатны баримт хөтлөлт хангалтгүй, бараа материалыг бөөн дүнгээр зарлагдсан; /Сэлэнгэ аймгийн ОБГ 133.1 сая, Архангай аймгийн ОБГ 45.2 сая/
- Бараа материалын санхүүгийн тайлангийн үлдэгдэл тооллогын бүртгэлээс зөрүүтэй илэрхийлэгдсэн; /Өвөрхангай аймгийн ОБГ 14.9 сая/
- Бараа материалын тооцоо бодоогүй, бэлэн бүтээгдэхүүний тайлан бэлтгээгүй; /ОБЕГ-ын дэргэдэх 121 дүгээр анги/ зэрэг

3.5.5 Нөөцийн бараа

Нөөцийн бараа дансны эцсийн үлдэгдэл 69,193.7 сая төгрөг болж, өмнөх оноос 1,303.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Нөөцийн бараа материал дансны үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барааны нөөц	38,407,876.6	34,769,321.8	-3,638,554.8
Үрийн нөөц	3,601,817.8	5,483,759.1	1,881,941.3
Тэжээлийн нөөц	8,828,024.8	8,933,307.5	105,282.7
Шатахууны нөөц	18,789,716.8	19,434,919.9	645,203.1
Бусад нөөц	869,700.9	572,379.8	-297,321.1
Дүн	70,497,136.9	69,193,688.2	-1,303,448.7

Эх сурвалж: ОБЕГ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нөөцийн бараа дансны үлдэгдэл буурсан нь сэлгэн шинэчлэлийн гэрээгээр улсын нөөцийн бараа материалаас худалдан борлуулж, анги салбар хооронд шилжүүлэн, сэлгэн шинэчилсэнтэй холбоотой байна.

3.5.6 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 12,675.4 сая төгрөг болж өссөн байна.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө	0.0	12,675,400.0	12,675,400.0
Дүн	0.0	12,675,400.0	12,675,400.0

Эх сурвалж: ОБЕГ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бусад эргэлтийн хөрөнгө дансанд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний 12,675.4 сая төгрөгийн дуусаагүй барилга, байгууламж бүртгэлтэй байна.

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 262,852.4 сая төгрөг болж, өмнөх оноос 58,163.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	175,162,797.0	233,078,480.3	57,915,683.2
Барилга, байгууламж, орон сууц	97,214,639.7	95,363,143.8	-1,851,495.9
Авто-тээврийн хэрэгсэл	63,821,580.6	112,533,133.3	48,711,552.7
Машин тоног төхөөрөмж(компьютер)	7,127,026.8	16,457,547.2	9,330,520.4
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,673,046.0	1,676,444.4	3,398.4
Зам, гүүрний байгууламж	56,501.9	91,734.9	35,233.0
Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	58,995.2	338,581.9	279,586.7
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	3,400.0	0.0	-3,400.0
Бусад үндсэн хөрөнгө	761,819.2	1,217,903.8	456,084.5
Дуусаагүй барилга, байгууламж	4,442,649.1	5,396,852.5	954,203.4
Ном	3,138.6	3,138.6	0.0
Биет бус хөрөнгө	29,526,551.8	29,773,877.3	247,325.6
Программ хангамж	36,007.2	123,985.1	87,977.9
Бусад биет бус хөрөнгө	29,490,544.6	29,649,892.2	159,347.7
Дүн	204,689,348.8	262,852,357.6	58,163,008.8

Эх сурвалж: ОБЕГ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өссөн нь Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагааны бэлтгэл бэлэн байдлыг сайжруулах арга хэмжээний хүрээнд Бүгд Найрамдах Франц, Беларусь Улс болон Монгол Улсын Засгийн газрын хоорондын зээлийн гэрээгээр гал унтраах болон тусгай зориулалтын 60,159.0 сая төгрөгийн 81 ширхэг автомашин авсан нь нөлөөлсөн байна.

Дуусаагүй барилга, байгууламж дансанд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр барьж байгаа нийслэлийн Чингэлтэй дүүргийн Гал унтраах 10 дугаар ангийн барилга, албан хаагчдын хандиваар барьж байгаа Давтан сургалт, сэргээн заслын төвийн хөл бөмбөгийн талбай, Хөвсгөл аймгийн ОБГ-ын харьяа Усны сургалтын төвийн зуны байр, Швейцарийн хөгжлийн агентлагийн төслөөр санхүүжсэн Аврах ажиллагааны байгууламж, Ховд аймгийн ОБГ-ын авто гарааш тус тус бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ашиглалтад байгаа хөрөнгийг шийдвэрлээгүй, дахин үнэлгээ хийлгээгүй; /Багахангай дүүргийн ОБХ 1,082.3 сая, Багануур дүүргийн ОБХ 910.7 сая, Үндэсний аврах бригад 750.7 сая, Чингэлтэй дүүргийн ОБХ 655.3 сая, Баянгол дүүргийн ОБХ 592.0 сая, Өмнөговь аймгийн ОБГ/
- Данс бүртгэлд байгаа боловч биетээр байхгүй, олон жил маргаантай, бүртгэл зөрүүтэй хөрөнгүүдийн асуудлыг эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлээгүй; /Хан-Уул дүүргийн ОБХ/
- Санхүүгийн тайланд хандиваар авсан 32 нэр төрлийн 69 ширхэг тоног төхөөрөмжийг үнэлж бүртгээгүй, ТӨБЗГ-ын 2021 оны А/1/1190 дугаар тогтоолоор акталж данснаас хассан, улсын дугаар бүхий 2 автомашиныг дуудлага худалдаанд оруулаагүй данс бүртгэлээс хассан; /Үндэсний аврах бригад/
- Үндсэн хөрөнгийн дансанд нийтийн эзэмшлийн явган хүний 2 зам, байршил тодорхойгүй 1 суварга бүртгэсэн; /ОБЕГ/
- Үндсэн хөрөнгийн ангиллыг буруу бүртгэсэн; /Сүхбаатар дүүргийн ОБХ 12.8 сая/ зэрэг

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 2,486.6 сая төгрөг болж, өмнөх оноос 488.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөр дансны үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Санхүүгийн бусад байгууллага	183,814.5	158,502.3	-25,312.1
Ажилчидтай холбогдсон өглөг	1,991.1	21,631.9	19,640.8
Бараа үйлчилгээний зардлын өглөг	4,710.7	1,496,738.0	1,492,027.3
Байгууллагад төлөх өглөг	2,141,830.9	808,367.2	-1,333,463.7
Хувь хүмүүст төлөх өглөг	27,468.3	859.3	-26,609.0
Дүн	2,975,432.5	2,486,598.8	-488,833.7

Эх сурвалж: ОБЕГ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өр төлбөр дансны үлдэгдэл буурсан нь хувцас тусгай хэрэгслийг гэрээний хугацаанд үйлдвэрлэж, нийлүүлээгүйгээс 1,492.4 сая төгрөгийн өглөг үүсгэсэн, тусгаарлах байрны иргэдийн 1,122.9 сая төгрөгийн өглөгийг барагдуулсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- Чанарын баталгааны 11.9 сая төгрөгийн өглөгийг өмнөх онд орлогоор бүртгэж, тайлант онд чөлөөлсөн; /ОБЕГ/
- Тайлант онд өглөг үүсгэсэн; /Давтан сургалт сэргээн заслын төв 11.5 сая/ зэрэг

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 406,318.0 сая төгрөг болж, өмнөх оноос 68,989.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	90,485,170.0	94,915,269.6	4,430,099.5
Хуримтлагдсан үр дүн	196,842,301.1	261,317,363.6	64,475,062.5
Өмнөх үеийн үр дүн	161,107,949.9	192,949,400.9	31,841,451.0
Тайлант үеийн үр дүн	35,734,351.2	68,367,962.7	32,633,611.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	50,000,876.0	50,085,346.0	84,470.1
Дүн	337,328,347.1	406,317,979.2	68,989,632.1

Эх сурвалж: ОБЕГ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь тайлант оны үр дүн 64,475.1 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Онцгой байдлын ерөнхий газар нь 2021 оны төсвийн төсөлд урсгал зардлыг 134,381.4 сая, хөрөнгийн зардлыг 24,017.5 сая, нийт 158,398.9 сая төгрөгийг төлөвлөж, 153,136.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 5,262.1 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр тооцон дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс нийт зардлыг 11,456.1 сая төгрөгөөр бууруулан 146,942.8 сая төгрөгөөр баталжээ. Тухайлбал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 2,036.4 сая, хангамж, бараа материалын зардлыг 1,645.3 сая, урсгал шилжүүлгийг 1,496.0 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 1,250.9 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,182.8 сая төгрөгөөр тус тус бууруулсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Онцгой байдлын ерөнхий газрын хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээнд зориулан урсгал зардалд 119,587.7 сая, хөрөнгийн зардалд 27,355.1 сая, нийт 146,942.8 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 141,498.0 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 5,346.4 сая төгрөгийн орлогыг олж, нийт 146,844.4 сая төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна. Үүнээс 117,936.2 сая төгрөгийг урсгал зардалд, 27,341.4 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулж, үлдэгдэл 1,566.8 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 145,277.6 сая төгрөг буюу 98.9 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1,097.0 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 365.6 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 8. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Код	Нэр				
1	70708	Гамшгаас урьдчилан сэргийлэх	146,942,807.9	145,277,565.4	1,665,242.5	98.9
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	99,250,861.8	97,619,843.8	1,631,018.0	98.4
1.2	80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	191,136.4	181,183.5	9,952.9	94.8
1.3	80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	4,910.6	4,669.6	241.0	95.1
1.4	80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	10,000.0	9,770.0	230.0	97.7
1.5	80220	Холбооны суваг ашигласны хөлс	449,176.1	449,176.1	0.0	100.0
1.6	80226	Байр ашиглалтын үйлчилгээ	5,504.4	5,504.4	0.0	100.0
1.7	80509	ОУ-ын байгууллагын гишүүнчлэл хураамж	106,010.0	105,735.8	274.2	99.7
1.8	80703	Өндөр настан, ахмад дайчдад олгох тэтгэмж	4,500.0	4,500.0	0.0	100.0
1.9	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	8,356,259.1	8,353,196.0	3,063.1	100.0
1.10	80813	Хуульд заасан үндэслэлээр алба хаагчид олгох нөхөн олговор	128,800.0	128,741.0	59.1	100.0
1.11	80918	Бусад	19,275,400.0	19,268,862.5	6,537.5	100.0
1.12	81560	Монголын улаан загалмай нийгэмлэгээр гэрээгээр гүйцэтгүүлэх	107,785.4	107,785.4	0.0	100.0

1.13	82310	Гамшгаас сэргийлэх сургалт, сургалт сурталчилгаа	538,774.7	533,496.6	5,278.1	99.0
1.14	82705	Байгалийн гамшиг, ослын үр дагаврыг арилгах	9,051,200.0	9,050,510.2	689.8	100.0
1.15	81301	Хүнс барааны нөөц	585,408.0	579,344.8	6,063.2	99.0
1.16	81302	Шатахууны нөөц	1,704,590.0	1,703,496.1	1,093.9	99.9
1.17	81303	Машин техникийн нөөц	1,442,000.0	1,442,000.0	0.0	100.0
1.18	81305	Өвс, тэжээлийн нөөц	2,496,000.0	2,495,909.7	90.3	100.0
1.19	81308	Үрийн нөөц	1,851,744.2	1,851,744.2	0.0	100.0
1.20	81310	Улсын нөөцийн барааны сэлгэлт, шинэчлэл	1,382,747.2	1,382,095.6	651.6	100.0

Онцгой байдлын ерөнхий газрын үйл ажиллагааны орлогыг 5,262.1 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 5,346.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Хүснэгт 9. Үйл ажиллагааны орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Улсын нөөцийн газар	4,500.0	4,707.9	207.9	104.6
Давтан сургалт сэргээн заслын төв	598.3	450.8	-147.5	75.3
Нийслэлийн ОБГ	163.8	183.8	20.0	112.2
Гамшиг судлалын хүрээлэн	0.0	3.9	3.9	-
Нийт дүн	5,262.1	5,346.4	84.3	101.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд ЗГНХ, ЗДНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс 22,090.5 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 7,066.5 сая, дээд шатны төсвийн захирагчаас доод шатны төсвийн захирагчид 5,087.3 сая, хандив тусламжаар 3,217.5 сая, нийт 37,461.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд 36,251.3 сая, хөрөнгийн зардалд 562.0 сая, нийт 36,813.3 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 648.5 сая төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар Шадар сайдын 2021 онд хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 19 арга хэмжээний хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг баталсан байна. Үүнээс Онцгой байдлын ерөнхий газар нь гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 97.6 хувийн биелэлттэй байна.

Онцгой байдлын ерөнхий газрыг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 “Онцгой байдлын байгууллага нь ... тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага мөн” гэж заасан байна.

Төрийн цэргийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, бие бүрэлдэхүүний тоо бүртгэл нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт заасны дагуу маш нууцын зэрэглэлд багтдаг байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгаанд анхаарал татсан асуудал гараагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Онцгой байдлын ерөнхий газрын үйл ажиллагаа, санхүүгийн холбогдох зарим мэдээллүүд нууцын зэрэглэлд хамаардаг бөгөөд нууцад хамаарах мэдээллийн төрөл, цар хүрээг тодорхой болгож, нарийвчлан гаргах шаардлагатай байна.

3.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Онцгой байдлын ерөнхий газар нь шилэн дансны цахим хуудсанд нийт 331,779.5 сая төгрөгийн ажил, гүйлгээний 6748 мэдээлэл байршуулахаас 134,383.8 сая төгрөгийн ажил, гүйлгээний 598 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 2,679.5 сая төгрөгийн ажил, гүйлгээний 48 мэдээллийг байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг хуулиар тогтоосон хугацаанд тогтмол мэдээлэх, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Онцгой байдлын ерөнхий газрын 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 49.5 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 204.0 сая төгрөгийн 3 албан шаардлага, 2,998.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 зөвлөмж өгснийг үнэлэхэд албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 55.6 хувьтай байна.

Хүснэгт 11. Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	49,500.0	1	49,500.0	-	-	100.0
Албан шаардлага	3	204,000.0	2	204,000.0	1		66.7
Зөвлөмж	1	2,998.500.0	-	-	1	2,998.500.0	-
Нийт дүн	5	3,252,000.0	3	253,500.0	2	2,998,500.0	55.6

Өмнөх оны аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулах 1 албан шаардлага, аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгахад арга хэмжээ авч ажиллах 1 зөвлөмж хэрэгжээгүй байна.

Иймд хэрэгжээгүй албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд Эрэлч нохойн сургалтын төвийг шинээр байгуулахаар 182.7 сая төгрөгийн төсөв баталсан байна. Эрэлч нохойн сургалтын төв байгуулагдаагүй, үйл ажиллагаагаа явуулаагүй бөгөөд ОБЕГ-ын дэргэдэх Уул уурхайн аврах 09 дүгээр ангийн төсвийн гүйцэтгэлийн тайланд баталсан төсвийг нэгтгэн тайлагнаж, зарцуулаагүй үлдэгдэл 182.7 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Онцгой байдлын ерөнхий газрын худалдан авах ажиллагаа, хандивын хөрөнгийн зарцуулалтыг цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан гүйцээн шалгаж амжаагүй тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 56,090.7 сая төгрөгийн 178 алдаа, зөрчил илрүүлснээс, 46,722.4 сая төгрөгийн 45 алдааг залруулж, 25.1 сая төгрөгийн зөрчилд 11 төлбөрийн акт тогтоож, 3,203.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд 42 албан шаардлага хүргүүлж, 6,139.9 сая төгрөгийн 80 алдаа зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

Залруулагдаагүй нийт алдаа, зөрчил 9,368.3 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 1,637.6 сая төгрөгөөс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

4.1 Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 46 төсвийн байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 36 байгууллагад дүгнэлт гаргаж, 10 байгууллагыг аудитын түүвэрт хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 35, “Хязгаарлалттай” 1 дүгнэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар нийт 41,508.6 сая төгрөгийн 173 алдаа, зөрчил илрүүлснээс, 32,827.7 сая төгрөгийн 44 алдааг залруулж, 23.6 сая төгрөгийн 10 төлбөрийн акт тогтоож, 2,517.4 сая төгрөгийн 39 албан шаардлага хүргүүлж, 6,139.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 80 зөвлөмжийг өгсөн.

4.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч

4.2.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулсан алдаа

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 13,894.7 сая төгрөгийн 4 алдааг залруулав. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайланд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний 12,675.4 сая төгрөгийн хөрөнгийг бүртгээгүй, бусад эргэлтийн хөрөнгөөр тайлагнасан;
- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн өмнөх оны үйл ажиллагааны орлого 64,861.3 сая, үйл ажиллагааны зардал 24,523.0 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн, тайлант онд 28.2 сая төгрөгийн орлого, зардал илүү илэрхийлэгдсэн;
- Өмчийн өөрчлөлтийн тайланд үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт 6.3 сая, үндсэн хөрөнгийн бууралт 96.7 сая, орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз 740.4 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй илэрхийлэгдсэн;
- Мөнгөн гүйлгээний тайланд өмнөх оны үйл ажиллагааны мөнгөн орлого 9,054.1 сая, нийт зардал 7,635.2 сая төгрөгөөр, тайлант онд бараа, ажил, үйлчилгээний зардал 347.7 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэнийг тус тус залруулав.

4.2.2 Төлбөрийн акт

“Монгол Улсын Онцгой байдлын албаны хот дотор эрэн хайх, аврах ажиллагааны чадавхыг сайжруулах нь” төслийн 2019-2020 оны санхүүгийн тайланг төрийн аудитын байгууллагад хүргүүлээгүй, нэр бүхий аудитын хуулийн этгээдээр санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгүүлэн аудитын төлбөрт 1.5 сая төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 “төсвийн шууд захирагч ... жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх”, 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар

зүйл “Санхүүгийн тайлангийн аудит”, 8.2 “Төрийн аудитын байгууллага төрийн чиг үүргийг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээдийн санхүүгийн тайланд аудит хийж болно.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын хуулийн этгээдэд олгосон аудитын төлбөр 1.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.2.3 Албан шаардлага

1. Онцгой байдлын ерөнхий газрын аппарат нь тайлант оны эцэст бичиг хэргийн материалд 20.0 сая, багаж, техник хэрэгсэлд 215.9 сая, бензин шатахуунд 420.0 сая нийт 655.9 сая төгрөгийг нэр бүхий байгууллагуудад шилжүүлж, урьдчилж төлсөн зардал дансанд бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж, дараа тооцоо үүсгэхгүй байх талаар албан шаардлага хүргүүлэв.

2. Харьяа 46 байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 8,680.9 сая төгрөгийн 129 алдаа зөрчил илэрсэн байна. Дотоод хяналт үр нөлөөгүй, сул байгаагаас алдаа, зөрчлийн дүн өмнөх оноос өссөн, өмнөх оны аудитаар өгсөн 93.7 сая төгрөгийн 5 албан шаардлага, 578.1 сая төгрөгийн 14 зөвлөмж хэрэгжээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 15.4.1 “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх”, 16 дугаар зүйлийн 16.5.6 “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, алдаа, зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллах, дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулах албан шаардлага хүргүүлэв.

3. Тайлант онд дөрвөөс дээш жилийн насжилттай авлагуудыг барагдуулаагүй, 30.0 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Олон жилийн насжилттай авлагыг барагдуулах, авлагыг тооцоо нийлж баталгаажуулах талаар албан шаардлага хүргүүлэв.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Үндэсний аудитын газарт 2022 оны 9 дүгээр сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/ Д	Байгууллагын нэр	Аудитын код	Аудитын санал дүгнэлт					Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:									
			Үүнээс							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
			Бүгд	Зөрчилгүй	Хягаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталаах	Түүвэрт хамруулсан	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо
Төсвийн төвлөрүүлэн захирагч																			
1	ОБЕГ - ТТЗ	АХГ- 2022/08/НА- СТА-ТТЗ	1		1			5	14,582,115.0	1	13,894,700.0	1	1,500.0	3	685,915.0			-	-
	Дүн		1		1			5	14,582,115.0	1	13,894,700.0	1	1,500.0	3	685,915.0			-	-
Төсвийн шууд захирагч																			
1	ОБЕГ - аппарат	АХГ- 2022/164/НА- СТА-ТШЗ	1	1				7	244,990.9					3	244,990.9			4	-
2	ОБЕГ-ын дэргэдэх Ар талын 115 дугаар анги	АХГ- 2022/170/НА- СТА-ТШЗ	1	1				2	17,900.0									2	17,900.0
3	ОБЕГ-ын хөрөнгө оруулалт, их засвар	АХГ- 2022/165/НА- СТА-ТШЗ	1				1	7	17,522,037.5	1	12,675,400.0			1	670,543.1			5	4,176,094.4
4	Давтан сургалт, сэргээн заслын тев 113 дугаар анги	АХГ- 2022/169/НА- СТА-ТШЗ	1	1				8	32,828.4	4	12,730.9			2	17,086.6			2	3,010.9
5	Үндэсний аврах бригад	АХГ- 2022/166/НА- СТА-ТШЗ	1	1				10	1,113,807.1	2	218,322.8	1	5,759.6	3	105,992.4			4	783,732.3
6	Гамшиг судлалын хүрээлэн	АХГ- 2022/171/НА- СТА-ТШЗ	1				1	-	-										
7	Аврагч биеийн тамир, техник спортын хороо 120 дугаар анги	АХГ- 2022/172/НА- СТА-ТШЗ	1				1	1	88,367.3	1	88,367.3								
8	ОБЕГ-ын дэргэдэх	АХГ- 2022/176/НА- СТА-ТШЗ	1				1	-	-										

Онцгой байдлын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	хүнсний нөөцийн 179 дүгээр анги																		
9	ОБЕГ-ын дэргэдэх шатахууны нөөцийн 112 дугаар анги	АХГ-2022/175/НА-СТА-ТШЗ	1				1	-	-										
10	ОБЕГ-ын дэргэдэх улсын нөөцийн 185 дугаар анги	АХГ-2022/174/НА-СТА-ТШЗ	1				1	-	-										
11	ОБЕГ-ын дэргэдэх Уул уурхайн аврах 09 дүгээр анги	АХГ-2022/168/НА-СТА-ТШЗ	1				1	1	-								1	-	
12	Агаараас эрэн хайх 111 дүгээр анги	АХГ-2022/167/НА-СТА-ТШЗ	1				1	3	387,417.5	2	387,417.5						1	-	
13	ОБЕГ-ын дэргэдэх ОТХХТҮТ-ийн 121 дүгээр анги	АХГ-2022/173/НА-СТА-ТШЗ	1				1	4	1,466,632.0				1	1,215,369.6			3	251,262.4	
14	ОБЕГ - Эрэлч нохойн сургалтын төв		1				1	-	-										
15	ОБЕГ - Улсын нөөцийн бараа бүрдүүлэлт сэлгэлт шинэчлэл		1		1			-	-										
16	Нийслэлийн ОБГ	НТАГ-2022/36/НА-СТА-ТШЗ	1	1				4	101,569.8	1	10,150.8	1	1,104.9	1	85,216.6	-	-	1	5,097.5
17	Багануур дүүргийн ОБХ	НТАГ-2022/47/НА-СТА-ТШЗ	1	1				5	57,270.2	2	38,070.2							3	19,200.0
18	Багахангай дүүргийн ОБХ	НТАГ-2022/50/НА-СТА-ТШЗ	1	1				2	8,128.3									2	8,128.3
19	Баянгол дүүргийн ОБХ	НТАГ-2022/39/НА-СТА-ТШЗ	1	1				7	112,691.6	3	95,829.9			2	7,161.7			2	9,700.0
20	Баянзүрх дүүргийн ОБХ	НТАГ-2022/45/НА-СТА-ТШЗ	1	1				2	16,475.7					1	9,574.0			1	6,901.7
21	Налайх дүүргийн ОБХ	НТАГ-2022/52/НА-СТА-ТШЗ	1	1				2	4,076.7					1	3,385.6			1	691.1
22	Сүхбаатар дүүргийн ОБХ	НТАГ-2022/61/НА-СТА-ТШЗ	1	1				5	36,030.9					2	21,330.0			3	14,700.9
23	Сонгинохайрхан дүүргийн ОБХ	НТАГ-2022/62/НА-СТА-ТШЗ	1	1				2	12,028.0									2	12,028.0

Онцгой байдлын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

24	Чингэлтэй дүүргийн ОБХ	НТАГ-2022/66/НА-СТА-ТШЗ	1	1			4	46,391.1	1	12,941.1					3	33,450.0
25	Хан-Уул дүүргийн ОБХ	НТАГ-2022/63/НА-СТА-ТШЗ	1	1			8	2,839,427.0	3	2,829,874.6		2	9,552.4		3	-
26	Архангай аймгийн ОБГ	АРА-2022/18/НА-СТА-ТШЗ	1	1			1	45,200.0							1	45,200.0
27	Баян-Өлгий аймгийн ОБГ	БӨА-2022/159/НА-СТА-ТШЗ	1	1			1	3,900.0							1	3,900.0
28	Баянхонгор аймгийн ОБГ	БНА-2022/98/НА-СТА-ТШЗ	1	1			6	38,406.0	1	33,775.0		2	-		3	4,631.0
29	Булган аймгийн ОБГ	ОРА-2022/115/НА-СТА-ТШЗ	1	1			6	9,386.4				1	220.0		5	9,166.4
30	Говь-Алтай аймгийн ОБГ	ГАА-2022/63-НА-СТА-ТШЗ	1	1			7	79,062.4	3	56,700.0	2	800.0	2	21,562.4		
31	Говьсүмбэр аймгийн ОБГ	ГСА-2022/14/СТА-ТШЗ	1	1			5	36,993.1	1				3	36,993.1	1	-
32	Дархан-Уул аймгийн ОБГ	ДАА-2022/123/НА-СТА-ТШЗ	1	1			3	15,716,021.8	2	15,712,352.1	1	3,669.7				
33	Дорноговь аймгийн ОБГ	ДГА-2022/117/НА-СТА-ТШЗ	1	1			5	87,300.0	1	65,500.0			3	21,800.0	1	-
34	Дорнод аймгийн ОБГ	ДОА-2022/180/НА-СТА-ТШЗ	1	1			3	2,800.0			2	2,500.0	1	300.0		
35	Дундговь аймгийн ОБГ	ДУА-2022/03/НА-СТА-ТШЗ	1	1			4	40,064.6	1	34,179.4	1	436.5	2	5,448.7		
36	Завхан аймгийн ОБГ	ЗАА-2022/201/СТА-ТШЗ	1	1			6	54,782.0	3	50,390.0					3	4,392.0
37	Орхон аймгийн ОБГ	ОРА-2022/25/НА-СТА-ТШЗ	1	1			10	127,834.2	1	32,000.0	2	9,355.1	1	1,000.0	6	85,479.1
38	Өвөрхангай аймгийн ОБГ	ӨВА-2022/129/НА-СТА-ТШЗ	1	1			6	151,800.0	3	134,400.0			2	17,400.0	1	-
39	Өмнөговь аймгийн ОБГ	ӨМА-2022/108/НА-СТА-ТШЗ	1	1			3	92,423.6	1	92,423.6					2	-
40	Сүхбаатар аймгийн ОБГ	СБА-2022/15/НА-СТА-ТШЗ	1	1			6	159,004.1	4	155,914.1					2	3,090.0
41	Сэлэнгэ аймгийн ОБГ	СЭА-2022/253/НА-СТА-ТШЗ	1	1			9	679,409.9	2	31,142.0			2	16,493.8	5	631,774.1
42	Төв аймгийн ОБГ	ТӨА-2022/02/НА-СТА-ТШЗ	1	1			4	70,179.9	1	59,842.8					3	10,337.1
43	Увс аймгийн ОБГ	УВА-2022/51/НА-СТА-ТШЗ	1	1			-	-								

**Онцгой байдлын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

44	Ховд аймгийн ОБГ	ХОА-2022/26/НА-СТА-ТШЗ	1	1					-	-										
45	Хөвсгөл аймгийн ОБГ	ХӨА-2022/241/НА-СТА-ТШЗ	1	1				3	-									3		-
46	Хэнтий аймгийн ОБГ	ХЭА-2022/11/НА-СТА-ТШЗ	1	1				1	6,000.0					1	6,000.0					
	Дүн		46	35	1	-	-	10	173	41,508,638.1	44	32,827,724.2	10	23,625.8	39	2,517,420.9	-	-	80	6,139,867.2
	Нийт дүн		47	35	2	-	-	10	178	56,090,753.1	45	46,722,424.2	11	25,125.8	42	3,203,335.9	-	-	80	6,139,867.2

5.2 Нийцлийн аудитын асуудлаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс																	
					Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж									
			тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн								
Төсвийн төвлөрүүлэн захирагч																						
1	ОБЕГ - ТТЗ	АХГ-2022/08/НА-СТА-ТТЗ	1	-					1	-												
	Дүн		1	-					1	-												
Төсвийн шууд захирагч																						
1	ОБЕГ - аппарат	АХГ-2022/164/НА-СТА-ТШЗ	1	3,133,425.5					1	3,133,425.5												
2	ОБЕГ-ын дэргэдэх Ар талын 115 дугаар анги	АХГ-2022/170/НА-СТА-ТШЗ	-	-																		
3	Онцгой байдлын ерөнхий газрын хөрөнгө оруулалт, их засвар	АХГ-2022/165/НА-СТА-ТШЗ	-	-																		
4	Давтан сургалт, сэргээн заслын төв 113 дугаар анги	АХГ-2022/169/НА-СТА-ТШЗ	1	419.0					1	419.0												
5	Үндэсний аврах бригад	АХГ-2022/166/НА-СТА-ТШЗ	1	1,022,167.5					1	1,022,167.5												
6	Гамшиг судлалын хүрээлэн	АХГ-2022/171/НА-СТА-ТШЗ	-	-																		
7	Аврагч биеийн тамир, техник спортын хороо 120 дугаар анги	АХГ-2022/172/НА-СТА-ТШЗ	1	-														1	-			
8	ОБЕГ-ын дэргэдэх хүнсний нөөцийн 179 дүгээр анги	АХГ-2022/176/НА-СТА-ТШЗ	-	-																		
9	ОБЕГ-ын дэргэдэх шатахууны нөөцийн 112 дугаар анги	АХГ-2022/175/НА-СТА-ТШЗ	-	-																		
10	ОБЕГ-ын дэргэдэх улсын нөөцийн 185 дугаар анги	АХГ-2022/174/НА-СТА-ТШЗ	-	-																		
11	ОБЕГ-ын дэргэдэх Уул уурхайн аврах 09 дүгээр анги	АХГ-2022/168/НА-СТА-ТШЗ	1	38,552.0														1	38,552.0			

Онцгой байдлын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

12	Агаараас эрэн хайх 111 дүгээр анги	АХГ-2022/167/НА-СТА-ТШЗ	1	64,460.4								1	64,460.4
13	ОБЕГ-ын дэргэдэх ОТХХТҮТ-ийн 121 дүгээр анги	АХГ-2022/173/НА-СТА-ТШЗ	-	-									
14	ОБЕГ - Эрэлч нохойн сургалтын төв		-	-									
15	ОБЕГ - Улсын нөөцийн бараа бүрдүүлэлт сэлгэлт шинэчлэл		-	-									
16	Нийслэлийн ОБГ	НТАГ-2022/36/НА-СТА-ТШЗ	1	50,000.0				1	50,000.0				
17	Багануур дүүргийн ОБХ	НТАГ-2022/47/НА-СТА-ТШЗ	-	-									
18	Багахангай дүүргийн ОБХ	НТАГ-2022/50/НА-СТА-ТШЗ	-	-									
19	Баянгол дүүргийн ОБХ	НТАГ-2022/39/НА-СТА-ТШЗ	1	1,188,232.9								1	1,188,232.9
20	Баянзүрх дүүргийн ОБХ	НТАГ-2022/45/НА-СТА-ТШЗ	-	-									
21	Налайх дүүргийн ОБХ	НТАГ-2022/52/НА-СТА-ТШЗ	-	-									
22	Сүхбаатар дүүргийн ОБХ	НТАГ-2022/61/НА-СТА-ТШЗ	1	189,672.1				1	189,672.1				
23	Сонгинохайрхан дүүргийн ОБХ	НТАГ-2022/62/НА-СТА-ТШЗ	-	-									
24	Чингэлтэй дүүргийн ОБХ	НТАГ-2022/66/НА-СТА-ТШЗ	-	-									
25	Хан-Уул дүүргийн ОБХ	НТАГ-2022/63/НА-СТА-ТШЗ	1	460,978.2				1	460,978.2				
26	Архангай аймгийн ОБГ	АРА-2022/18/НА-СТА-ТШЗ	-	-									
27	Баян-Өлгий аймгийн ОБГ	БӨА-2022/159/НА-СТА-ТШЗ	-	-									
28	Баянхонгор аймгийн ОБГ	БНА-2022/98/НА-СТА-ТШЗ	-	-									
29	Булган аймгийн ОБГ	ОРА-2022/115/НА-СТА-ТШЗ	-	-									
30	Говь-Алтай аймгийн ОБГ	ГАА-2022/63-НА-СТА-ТШЗ	2	18,900.0								2	18,900.0
31	Говьсүмбэр аймгийн ОБГ	ГСА-2022/14/СТА-ТШЗ	-	-									
32	Дархан-Уул аймгийн ОБГ	ДАА-2022/123/НА-СТА-ТШЗ	1	368,203.7				1	368,203.7				
33	Дорноговь аймгийн ОБГ	ДГА-2022/117/НА-СТА-ТШЗ	-	-									
34	Дорнод аймгийн ОБГ	ДОА-2022/180/НА-СТА-ТШЗ	-	-									
35	Дундговь аймгийн ОБГ	ДУА-2022/03/НА-СТА-ТШЗ	-	-									

Онцгой байдлын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

36	Завхан аймгийн ОБГ	ЗАА-2022/201/СТА-ТШЗ	-	-										
37	Орхон аймгийн ОБГ	ОРА-2022/25/НА-СТА-ТШЗ	-	-										
38	Өвөрхангай аймгийн ОБГ	ӨВА-2022/129/НА-СТА-ТШЗ	-	-										
39	Өмнөговь аймгийн ОБГ	ӨМА-2022/108/НА-СТА-ТШЗ	-	-										
40	Сүхбаатар аймгийн ОБГ	СБА-2022/15/НА-СТА-ТШЗ	-	-										
41	Сэлэнгэ аймгийн ОБГ	СЭА-2022/253/НА-СТА-ТШЗ	-	-										
42	Төв аймгийн ОБГ	ТӨА-2022/02/НА-СТА-ТШЗ	-	-										
43	Увс аймгийн ОБГ	УВА-2022/51/НА-СТА-ТШЗ	-	-										
44	Ховд аймгийн ОБГ	ХОА-2022/26/НА-СТА-ТШЗ	-	-										
45	Хөвсгөл аймгийн ОБГ	ХӨА-2022/241/НА-СТА-ТШЗ	-	-										
46	Хэнтий аймгийн ОБГ	ХЭА-2022/11/НА-СТА-ТШЗ	-	-										
	Дүн		13	6,535,011.3	-	-	-	-	7	5,224,866.0	-	-	6	1,310,145.3
	Нийт дүн		14	6,535,011.3	-	-	-	-	8	5,224,866.0	-	-	6	1,310,145.3



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 25 № 155/А0140080

Улаанбаатар хот

АХГ-2022/08/НБ-СТА-ТӨВ
Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Монгол Улсын Онцгой байдлын албаны хот дотор эрэн хайх, аврах ажиллагааны чадавхыг сайжруулах нь” төслийн 2019-2020 оны санхүүгийн тайланг төрийн аудитын байгууллагад хүргүүлээгүй, нэр бүхий аудитын хуулийн этгээдээр санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгүүлэн, аудитын төлбөр 1,500,000.00 төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 “төсвийн шууд захирагч ... жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх”, 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйл “Санхүүгийн тайлангийн аудит” 8.2 “Төрийн аудитын байгууллага төрийн чиг үүргийг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээдийн санхүүгийн тайланд аудит хийж болно.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Аудитын хуулийн этгээдэд олгосон аудитын төлбөр 1,500,000.0 /Нэг сая таван зуун мянга/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуян, ерөнхий нягтлан бодогч М.Хаш-Эрдэнэ нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРТҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ц.ЭНХЖАРГАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3 Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

9006109
9019120396

\\10.10.10.20\Bichig_Khereg\Akt\2022\0325 Auditin 2 Gazar-87.Docx

0001090366



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25

№ 742/АОН0080

Улаанбаатар хот

АХГ - 2022/08/НА - СТА - ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд дөрвөөс дээш жилийн насжилттай авлагыг барагдуулаагүй, 30,000,000.00 төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Олон жилийн насжилттай авлагыг үе шаттай барагдуулах, авлагыг тооцоо нийлж, баталгаажуулах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуян, ерөнхий нягтлан бодогч М.Хаш-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ц.ЭНХЖАРГАЛ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0325_Auditin_2_Gazar-388.Docx

0001001892



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 143/0110080

Улаанбаатар хот

АХГ - 2022/08/НА - СТА - Т13
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны эцэст бичиг хэргийн материалд 20,000,000.00 төгрөг, багаж, техник хэрэгсэлд 215,915,000.00 төгрөг, шатахуунд 420,000,000.00 төгрөг, нийт 655,915,000.00 төгрөгийг нэр бүхий байгууллагуудад урьдчилан шилжүүлж, урьдчилж төлсөн зардал дансанд бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 7 дугаар зүйлийн 7.7 "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Дараа оны бараа, ажил, үйлчилгээний төлбөрийг урьдчилан шилжүүлэхгүй, бараа материалын нөөц үүсгэхгүй байх, тайлант оны зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт татан төвлөрүүлэх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуян, ерөнхий нягтлан бодогч М.Хаш-Эрдэнэ нар т даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ц.ЭНХЖАРГАЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 747/А0170080
АХГ-2022/08/НА-СТА-ТТЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Харьяа 46 байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 8,680,913,900.00 төгрөгийн 129 алдаа, зөрчил илэрсэн байна. Дотоод хяналт үр нөлөөгүй, сул байгаагаас залруулагдаагүй алдаа зөрчил өмнөх оноос өссөн, өмнөх оны аудитаар өгсөн 93,710,000.00 төгрөгийн 1 албан шаардлага, 578,077,600.00 төгрөгийн 14 зөвлөмж хэрэгжээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:", 15.4.1 "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.6 "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, алдаа зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллах, дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуян, ерөнхий нягтлан бодогч М.Хаш-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ц.ЭНХЖАРГАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

9019120396

10.10.2020 Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0325 Auditin 2 Gazar-393.Docx

0001001004



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 746/А0170080

Улаанбаатар хот

АХГ-2022/08/НА-СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд харьяа 46 байгууллагын 331,779,502,200.00 төгрөгийн ажил, гүйлгээний 6748 мэдээлэл байршуулахаас 134,383,802.00 төгрөгийн ажил, гүйлгээний 598 мэдээллийг хугацаа хоцроож, 2,679,497,400.00 төгрөгийн дүн бүхий 48 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, 6.1.3, 6.1.4, 6.1.5, 6.1.6 дахь заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Харьяа байгууллагуудын шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг хуулиар тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлэх, хэрэгжилтэд хяналт тавих, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуян, ерөнхий нягтлан бодогч М.Хаш-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ц.ЭНХЖАРГАЛ

